



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТӨМӨРБУЛАГ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/122

Төмөрбулаг сум

Үрьдчилан сэргийлэх халдвартгүйтгэлийн
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 12,66 дугаар зүйлийн 66.1, МАл амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймгийн засаг даргын 2024 оны 03 сарын 25-ны өдрийн А/122 захирамж, мал эмнэлгийн газрын даргын А/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн мал эмнэлгийн газрын даргын төлөвлөгөөний дагуу малын гоц халдварт болон халдварт өвчний тархалтаас үрьдчилан сэргийлж бэлчээр, бууц хашаа хороо, зоорь, уст цэг, усны эх цэвэрлэх халдвартгүйтгэлийн ажлыг 2024 оны 04 сарын 05-ны өдрөөс эхлэн 05 сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд заавар стандартын дагуу сумын хэмжээнд зохион байгуулахыг мал эмнэлгийн нэгжийн эздэд үүрэг болгосугай.

2. Ариутгал халдвартгүйтгэл хийх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Ариутгал халдвартгүйтгэлийн ажлын зохион байгуулалтыг хийж хамтран ажиллахыг багуудын засаг дарга нарт даалгасугай.

4. Ариутгал халдвартгүйтгэлийн арга хэмжээг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хяналт тавьж, холбогдох мэдээ тайланг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэнд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тамгын газрын дарга (Г.Нямханд)-д даалгасугай.



ДАРГА

А.МОНХ-ЭРДЭНЭ